МОНГОЛ УЛСЫН
ЭРҮҮЛ МЭНДИЙН САЙДЫН ТУШААЛ

2014 оны 10 сарын 27 өдөр Дугаар 358 Улаанбаатар хот

Томуу, томуу төст өвчний харуулдан
тандалтын тогтолцоог өргөжүүлэх тухай

ДЭМБ-ын Дэлхийн томуугийн глобал сүлжээний гишүүн улс орнуудын шинжээчдийн боловсруулж, баталсан "Дэлхийн томуугийн тандалтын стандарт"-ыг удирдлага болгон томуугийн лабораторид суурилсан харуулдан тандалтын тогтолцоог цаашид тогтвортой хөгжүүлэх зорилгоор ТУШААХ нь:

1. "Томуугийн харуулдан тандалтын удирдамж"-ийг нэгдүгээр, "Томуугийн харуулдан тандалтын мэдээг нэгтгэх маягтуудын загвар"-ыг хоёрдугаар, "Томуу, томуу төст өвчний улирал угтуулж болон дэгдэлтийн үед авах арга хэмжээний заавар"-ыг гуравдугаар, "Харуулдан тандалтын сорьц авах, хадгалах, тээвэрлэх журам"-ыг дөрөвдүгээр, "Томуугийн тандалтын тогтвортой хөгжлийн төлөвлөгөө"-г тавдугаар, "Томуугийн харуулдан тандалтын I, II зэрэглэлийн нэгжийн жагсаалт"-ыг зургаадугаар хавсралтаар тус тус баталсугай.

2. Томуугийн тандалтын тогтолцооны тогтвортой үйл ажиллагааг хангахад шаардлагатай хөрөнгийг Эрүүл мэндийн яамны болон холбогдох эрүүл мэндийн байгууллагуудын жил бүрийн төсөвт 2015 оноос эхлэн тусгах, Ховд, Дорнод аймгууд дахь Бүсийн оношилгоо, эмчилгээ-ийн Вирус судлалын лабораторид шаардагдах тоног төхөөрөмжийг төсөл, хөтөлбөрийн шугамаар хангах ажлыг зохион байгуулахыг Төрийн нарийн бичгийн дарга (А.Эрдэнэтуяа)-д үүрэг болгосугай.

3. Халдварт өвчин судлалын үндэсний төвийн захирал (Д.Нямхүү)-д даалгах нь:
   3.1 Томуугийн тандалт, цартахлаас сэргийлэх, бэлэн байдлыг хангах арга хэмжээг үндэсний хэмжээнд зохион байгуулах, Дархан-Уул, Орхон, Дорнод, Ховд аймгийн Вирус судлалын лабораторийн эмч, мэргэжилтнийг сурган мэргэшүүлэх, тэдгээрийн үйл ажиллагааг мэргэжил арга зүйн удирдлагаар хангаж ажиллах;
   3.2 Томуугийн вирусын эргэлтийн хүрээг тогтоох зорилгоор холбогдох насны бүлгээс цусны сорьц цуглуулан ийлдсийн банк бүрдүүлэх, ашиглах журмыг

032249

2014 оны 12 дугаар сард багтаан гаргаж Эрүүл мэндийн сайдын тушаалаар батлуулан, мөрдүүлэх;

3.3 Томуугийн харуулдан тандалтын нэгжүүдийн нэгдсэн зөвлөлгөөнийг жил бүрийн 9 дүгээр сарын сүүлчийн долоо хоногт багтаан зохион байгуулж байх.

4. ХӨСҮТ-ийн Томуугийн төв лаборатори, Орхон, Дархан Уул, Ховд, Дорнод аймгууд дахь Вирус судлалын салбар лабораторид сорьц тээвэрлэж хүргэх зардал болон Томуугийн тандалтын нэгжийн хэвийн үйл ажиллагааг хангахад шаардлагатай хөрөнгийг 2015 оноос эхлэн орон нутгийн төсөвт тусгаж, халдварт өвчний үүсгэгч илрүүлэх нотолгоонд суурилсан тандалт хийж ажиллахыг Аймгуудын Эрүүл мэндийн газар, томуугийн харуулдан тандалтын нэгжээр сонгогдсон эрүүл мэндийн байгууллагуудын дарга, захирал нарт даалгасугай.

5. Вирус судлалын салбар лабораторид шаардлагатай оношлуур, урвалж, хэрэгслийн зардлыг орон нутгийн төсөвт тусгаж, лабораторийг бусад вируст халдварын онош, тандалтад ашиглахаар шат дараалан бэхжүүлэн, үйл ажиллагааны тогтвортой байдлыг хангаж ажиллахыг Орхон, Дархан Уул, Ховд, Дорнод аймгийн Эрүүл мэндийн газрын дарга нарт даалгасугай.

6. Шувуу, адуу, гахай болон бусад амьтны томуугийн вирусын байгаль дах эргэлтийг тандан судлах ажлыг мал эмнэлгийн салбартай хамтран зохион байгуулахыг Зоонозын өвчин судлалын үндэсний төв (М.Нямсүрэн)-д үүрэг болгосугай.

7. Энэхүү тушаал гарсантай холбогдуулан Эрүүл мэндийн сайдын 2002 оны 232 тоот тушаалын хоёрдугаар хавсралт, 2009 оны 323 тоот тушаалыг тус тус хүчингүй болсонд тооцсугай.

8. Энэхүү тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Бодлогын хэрэгжилтийг зохицуулах газар (Я.Буянжаргал)-т даалгасугай.

САЙД Н. УДВАЛ

Эрүүл мэндийн сайдын 2014 оны
10 сарын 27 өдрийн 358 дугаар
тушаалын 1 дүгээр хавсралт

ТОМУУГИЙН ХАРУУЛДАН ТАНДАЛТЫН УДИРДАМЖ

Нэг. Нийтлэг үндэслэл

1.1 Сонгосон тандалтын нэгжүүдээс тогтоосон удирдамжийн дагуу томуу, томуу төст өвчин (ТТӨ), амьсгалын замын хүнд халдвар (АЗХХ)-ын өвчлөлтэй холбоотой эмнэл зүйн болон лабораторийн шинжилгээний мэдээллийг тогтмол цуглуулан, дүн шинжилгээ хийж, бүх шатны эрүүл мэндийн байгууллагууд, шийдвэр гаргагчдыг эргэн мэдээллээр хангах чиг үүрэг бүхий тогтолцоог томуугийн харуулдан тандалт гэнэ.

1.2 Томуугийн шинж байдал, босго үзүүлэлтийг тодорхойлох, улирлын томуугийн өвчлөлийг үүсгэж буй вирусийн омгийг тодорхойлох, урьдчилан сэргийлэх арга хэмжээний стратегийг боловсруулах, томуу томуу төст өвчний дэгдэлтийг эрт илрүүлэх, түргэвчилсэн үнэлгээ хийж, хариу арга хэмжээг шуурхай хэрэгжүүлэх боломжийг бүрдүүлэх нь томуугийн харуулдан тандалтын тогтолцооны үндсэн зорилго мөн.

Хоёр. Томуугийн харуулдан тандалтын нэгжийн үйл ажиллагааны чиглэл

2.1 Томуугийн харуулдан тандалтад дараах тодорхойлолтыг ашиглана.

2.1.1 Сүүлийн 10 хоногт гэнэт 38°C хэм, түүнээс дээш өндөр халуурах, ханиалгах зэрэг эмнэл зүйн шинж тэмдэг илэрсэн амьсгалын замын цочмог халдварын тохиолдлыг **"томуу, томуу төст өвчин";**

2.1.2 Томуу, томуу төст өвчний шинж тэмдэг бүхий (2.1.1-д заасан) өвчтөн эмнэлэгт хэвтэн эмчлүүлэх шаардлагатай тохиолдлыг **"амьсгалын замын хүнд халдвар";**

2.1.3 Нэг хамтлаг, хамт олны дунд 2 ба түүнээс дээш хүнд 10 хоногийн хугацаанд эмнэлзүйн адил шинж тэмдэг гэнэт илрэхийг "**голомтолсон өвчлөл**" гэж тус тус үзнэ.

2.1.4 Томуу, томуу төст өвчин, амьсгалын замын хүнд халдвар, голомтолсон өвчлөл гэсэн тохиолдлыг тодорхойлолтын дагуу оношлосон эмч, эмчилгээ эхлэхээс өмнө өвчний эхний 3 хоногт сорьцыг цуглуулна.

2.2 Томуугийн харуулдан тандалтын нэгжийг хоёр зэрэглэлд ангилна.

2.3 Томуугийн харуулдан тандалтын I зэрэглэлийн нэгжүүдэд Дархан-Уул, Дорноговь, Дорнод, Ховд, Орхон, Өвөрхангай, Сэлэнгэ аймгийн нэгдсэн эмнэлэг, өрхийн эрүүл мэндийн төв, Дорноговь аймгийн Замын-Үүд сумын эрүүл мэндийн төв, өрхийн эрүүл мэндийн төв, Улаанбаатар хотын 8 дүүргийн өрхийн эрүүл мэндийн төвүүд, Бүсийн оношилгоо эмчилгээний төвүүд, ЭХЭМҮТ, ХӨСҮТ багтана.

2.4 Томуугийн харуулдан тандалтын I зэрэглэлийн нэгжийн эмч бүр ТТӨ, АЗХХ-ын тохиолдол болон голомтолсон өвчлөлийг 2.1-т заасан тодорхойлолтын дагуу тусгайлан бүртгэж, шалгуур үзүүлэлтийн дагуу үнэлэн, шалгуурт тохирсон өвчтнөөс сорьц цуглуулна.

2.5 Цуглуулсан сорьцыг 7 хоног тутам Сэлэнгэ, Дархан-Уул аймгийн тандалтын нэгжүүд Дархан-Уул аймаг дах; Булган, Орхон аймгийн тандалтын нэгжүүд Орхон аймаг дах; 1-р зэрэглэлийн бусад нэгжүүд ХӨСҮТ-ийн Вирус судлалын лабораторид тус тус хүргүүлнэ.

2.6 Томуугийн харуулдан тандалтын II зэрэглэлийн нэгжүүдэд энэхүү удирдамжийн 2.3-д зааснаас бусад аймгуудын төвийн өрхийн эрүүл мэндийн төв, аймгийн нэгдсэн эмнэлгүүд, хилийн боомт буюу орчил ихтэй, 10000-аас дээш хүн амтай зарим сум, суурин газрууд (Сэлэнгэ аймгийн Мандал, Алтанбулаг, Өвөрхангай аймгийн Хархорин), Улаанбаатар хотын Улсын нэгдүгээр төв эмнэлэг, Улсын гуравдугаар төв эмнэлэг, Хавдар судлалын үндэсний төв багтана.

2.7 Томуугийн харуулдан тандалтын II зэрэглэлийн нэгжийн эмч бүр ТТӨ, АЗХХ-ын тохиолдол ба голомтолсон өвчлөлийг 2.1-т заасан тодорхойлолтын дагуу тусгайлан бүртгэж, шалгуур үзүүлэлтийн дагуу үнэлэн, шалгуурт тохирох өвчтнүүдээс хамар залгиурын сорьц цуглуулж, ХӨСҮТ-ийн Вирус судлалын лабораторид хуваарийн дагуу хүргүүлнэ.

Гурав. Томуугийн харуулдан тандалтын мэдээ интернэтээр дамжуулах заавар

3.1 Өрхийн эрүүл мэндийн төвийн дүн бүртгэгч өдөр бүр эмч тус бүрээс ТТӨ, АЗХХ-ийн мэдээг авч, "Маягт 1"-ын дагуу нэгтгэн төвийн ахлагчаар хянуулж, ХӨСҮТ-ийн Томуугийн үндэсний төв (ТҮТ)-ийн www.flu.mn вэб хуудсаар өдөр бүр мэдээлнэ.

3.2 Аймгийн Эрүүл мэндийн газар, дүүргийн Эрүүл мэндийн нэгдлийн Томуугийн тандалт хариуцсан халдвар судлагч эмч эсвэл дүн бүртгэгч нь Өрхийн эрүүл мэндийн төв, Сумын эрүүл мэндийн төвөөс ТТӨ, АЗХХ-ийн мэдээг авч нэгтгэн "Маягт 1"-ын дагуу ТҮТ-ийн www.flu.mn вэб хуудсанд цахим хэлбэрээр 7 хоногт нэг удаа тогтмол мэдээлнэ.

3.3 Аймаг, дүүргийн нэгдсэн эмнэлгийн томуугийн тандалт хариуцсан халдвар судлагч эмч эсвэл дүн бүртгэгч нь "Маягт 2"-ын дагуу ТҮТ-ийн www.flu.mn вэб хуудсанд цахим хэлбэрээр 7 хоногт нэг удаа тогтмол мэдээлнэ.

3.4 Өдөр тутмын мэдээг дараа өдрийн 12 цагаас өмнө, 7 хоног тутмын мэдээг дараа 7 хоногийн Мягмар гарагийн 12 цагаас өмнө тус тус мэдээлсэн байна. Заасан хугацаанаас хойш ирүүлсэн мэдээг хоцорсонд тооцно.

Эрүүл мэндийн сайдын 2014 оны
10 сарын 27 өдрийн 358 дугаар
тушаалын 2 дугаар хавсралт

Маягт 1. Амбулаторт суурилсан тандалтын ТТӨ, АЗХХ-ын мэдээний бүртгэл

Үзүүлэлт	**Насны бүлэг**											
	0-11 сар	1 нас	2-4 нас	5-9 нас	10-14 нас	15 нас	16-24 нас	25-44 нас	45-49 нас	50-64 нас	65=<	Нийт
Амбулаторийн нийт үзлэгийн тоо												
Үүнээс ТТӨ-ий нийт тохиолдлын тоо												
Үүнээс: Голомтолсон өвчлөлийн тохиолдол[1]												
Амбулаторийн нийт үзлэгт ТТӨ-ий эзлэх хувь												
Түргэн тусламжийн дуудлагын тоо												
Үүнээс ТТӨ-ий шалтгаантай дуудлагын тоо												

[1] Голомтолсон өвчлөл бүртгэгдсэн тохиолдолд "нийт" гэсэн багананд өвчлөлд өртсөн хамтлагийн тоог тавина. Жишээ нь 3 айлын 7 хүн амьсгалын замын халдвараар 7 хоногийн хугацаанд өвчилсөн бол "нийт" багананд 3 гэсэн тоог тавьж, 7 тохиолдлыг насны бүлгээр бүртгэнэ.

Маягт 2. Эмнэлэгт суурилсан тандалтын ТТӨ, АЗХХ-ын мэдээний бүртгэл (зөвхөн уушги судлалын тасаг, хүүхдийн тасгаас авна)

Үзүүлэлт	Насны бүлэг											
	0-11 сар	1 нас	2-4 нас	5-9 нас	10-14 нас	15 нас	16-24 нас	25-44 нас	45-49 нас	50-64 нас	65=<	Нийт
Өнгөрсөн 7 хоногийн эцэст байсан нийт өвчтөн												
Эдгэрч гарсан, шилжсэн												
Нас барсан												
Шинээр хэвтсэн												
Энэ 7 хоногийн эцэст байгаа												
Үүнээс: Уушгины үрэвсэл(АЗХХ)-ээр хүндэрсэн												
Өнгөрсөн 7 хоногийн эцэст байсан нийт өвчтөн												
Эдгэрч гарсан, шилжсэн												
Нас барсан												
Шинээр хэвтсэн												
Энэ 7 хоногийн эцэст байгаа												

Эрүүл мэндийн сайдын 2014 оны
10. сарын 27 өдрийн 358 дугаар
тушаалын 3 дугаар хавсралт

ТОМУУ, ТОМУУ ТӨСТ ӨВЧНИЙ УЛИРАЛ УГТУУЛЖ БОЛОН ДЭГДЭЛТИЙН ҮЕД АВАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ЖУРАМ

Нэг. ТТӨ-ий улирал угтуулж болон дэгдэлтийн үед ХӨСҮТ-ийн Томуугийн үндэсний төвийн хэрэгжүүлэх арга хэмжээний чиглэл

1.1. ТТӨ-ий тархалтын түвшнийг долоо хоногоор тогтоож, олон жилийн хөдлөл зүйд суурилан хандлага, хэтийн төлвийг тодорхойлон, дэгдэлтийг угтуулан авах арга хэмжээг боловсруулж шийдвэрлүүлэх;

1.2. Томуугийн цартахалтай тэмцэх, хохирол багатай давах арга хэмжээний үндсэн чиглэл, төлөвлөгөөг боловсруулж, жил бүр тодотгол хийж, хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах;

1.3. Жил бүрийн томуугийн дэгдэлт болон голомтлог өвчлөлийн үед шинжлэгдэхүүн цуглуулж, вирус судлалын шинжилгээ хийх;

1.4. Лабораторид ялгасан томуугийн вирусын хэвшинж, дэд хэвшинж, эмийн бодист тэсвэржилтийг болон Монгол улсад орчиж буй ТТӨ-ий бусад үүсгэгчийг дүйн тодорхойлж, ДЭМБ, ЭМЯ, эрүүл мэндийн байгууллага, эмч мэргэжилтнүүдэд мэдээлж байх;

1.5. Томуугийн вирусын зарим омгууд, ялангуяа тухайн жилийн вакцины омгийн эсрэг дархан ийлдэст бага таньцтай дүйгдсэн болон дэд хэвшинж тодорхойгүй омгуудыг ДЭМБ-ын Томуугийн лавлагаа төвүүдэд илгээх;

1.6. Томуугийн тандалтын мэдээллийг долоо хоног бүр ДЭМБ-ын FluNet, FluID сүлжээ болон үндэсний www.flu.mn вэб хуудсанд тавьж, мэдээллийг шуурхай солилцож ажиллах;

1.7. Томуу өвчинтэй тэмцэх, сэргийлэх сургалт сурталчилгааны ажлыг холбогдох байгууллагуудтай хамтран зохион байгуулах;

1.8. Томуугийн үүсгэгчийн болон тархвар судлалын тандалтын орчин үеийн аргуудыг өөрийн орны нөхцөлд тохируулан нэвтрүүлэх, үндэсний хэмжээнд томуугийн харуулдан тандалтын нэгжүүдийг мэргэжил арга зүйн удирдлагаар хангах;

1.9. Хүн амд хэрэглэх улирлын томуугийн вакциныг сонгож, захиалах ажлыг Дархлаажуулалтын албатай хамтран гүйцэтгэх;

Хоёр. Бүх шатны эрүүл мэндийн байгууллагууд, засаг захиргааны нэгжүүдийн хэрэгжүүлэх арга хэмжээний чиглэл

2.1. ТТӨ амбулаторийн нийт үзлэгийн **4 хүртэлх хувийг эзэлж** байх үед буюу томуугийн **улирал угтуулж** дараахь арга хэмжээг хэрэгжүүлнэ. Үүнд:

2.1.1. Эрүүл мэндийн байгууллагууд ТТӨ-тэй тэмцэх, сэргийлэх арга хэмжээний төлөвлөгөөнд тодотгол хийх;

2.1.2. Томуугийн эсрэг дархлаажуулалтад эмнэлэг, эрүүл мэндийн байгууллагын эмч, ажилтан, жирэмсэн эмэгтэй, 5 хүртэл насны хүүхэд, 65-аас дээш насны болон бусад эрсдэлт бүлгийн хүн амыг хамруулах ажлыг зохион байгуулах;

2.1.3. Лабораторид шаардлагатай оношлуур, урвалж бодисын нөөцийг бэлэн болгох;

2.1.4. Эмнэлгийн тусламж үйлчилгээнд шаардлагатай эм, бэлдмэл, тоног төхөөрөмжийн хангамж, хүрэлцээ, бэлэн байдлыг хангах;

2.1.5. Эрүүл мэндийн байгууллагын эмч, эмнэлгийн мэргэжилтнүүдийг ТТӨ-ий өвчлөлийн эргэн мэдээллээр хангаж, идэвхжлийн талаар болон өртөмтгий бүлэгт хандсан үйл ажиллагааг зохион байгуулах, удаах шатныхаа байгууллагуудад шуурхай хүргүүлэх;

2.1.6. Хүн амын дунд "Томуу, томуу төст халдвараас сэргийлье" сэдэвт мэдээлэл, сургалт, сурталчилгааг зохион байгуулах;

2.2. ТТӨ амбулаторийн үзлэгт **5-9 хүртэлх хувийг эзэлж**, томуугийн **идэвхжил нэмэгдэж, алаг цоог дэгдэлт бүртгэгдэх үед** дараах арга хэмжээг хэрэгжүүлнэ. Үүнд:

2.2.1. Томуугийн улмаас хүндэрч болзошгүй жирэмсэн эмэгтэйчүүд, эрхтэн тогтолцооны эмгэг, архаг хууч өвчтэй эрсдэлт бүлгийн хүн амыг тодорхойлж, тэдэнд тавих өрхийн эмчийн хяналтыг сайжруулан, эрүүл мэндийн тусламж үйлчилгээ, нөөцийг зөв зохистой хуваарилж, хүргэх;

2.2.2. Эмч нарт вирусын эсрэг ямар эм, эмийн бэлдмэл хэрэглэх, томуугийн вирус хүн амын дунд идэвхитэй эргэлтэнд орсон үед лабораторийн шинжилгээний хариу хүлээлгүйгээр вирусын эсрэг эм (тамифлю)-ийг хүндэрч болзошгүй, хүнд өвчтөнд яаралтай хэрэглэхийг зөвлөх;

2.2.3. Түргэн тусламжийн үйлчилгээний унаа, эмч нарыг нэмэгдүүлэх, ӨЭМТ-ийн болон амбулаторийн эмч нарын ажлын цагийг уртасган ажиллуулах;

2.3. ТТӨ амбулаторийн үзлэгт **10-15 хүртэлх хувийг эзэлж, бүс нутгийн хэмжээнд томуугийн дэгдэлт явагдах** үед дараах арга хэмжээг хэрэгжүүлнэ. Үүнд:

2.3.1. Эмнэлгийн орны ачааллыг зохицуулах, орны тоог нэмэгдүүлэх, нэмэлт эмнэлэг дэлгэх төлөвлөгөөтэй байж, түүнийг шуурхай, шат дараалан хэрэгжүүлэх, ӨЭМТ-ийн эмчийн үзлэгийг гэрийн үйлчилгээнд бүрэн шилжүүлэх;

2.3.2. Эрсдэлтэй бүлгийн өвчтөнд үзүүлэх эмнэлгийн тусламж, үйлчилгээ, урьдчилан сэргийлэлтийг сайжруулж, цаг алдалгүй үзүүлэх;

2.4. ТТӨ амбулаторийн үзлэгт **15% ба түүнээс дээш хувийг эзэлж, улсын хэмжээнд томуугийн дэгдэлт явагдах үед** дараах арга хэмжээг хэрэгжүүлнэ. Үүнд:

2.4.1. Цэцэрлэг, сургууль зэрэг хүүхдийн байгууллагуудыг түр хаах, үзвэр үйлчилгээ, нийтийн цуглааныг хязгаарлах арга хэмжээг холбогдох байгууллагуудтай хамтран шийдвэрлэх;

Гурав. Ерөнхий боловсролын сургууль, цэцэрлэг болон хүүхдийн байгууллагуудын хэрэгжүүлэх арга хэмжээний чиглэл

3.1. Сургууль, цэцэрлэгийн анги танхим, биеийн тамир, хурлын зааланд чийгтэй цэвэрлэгээ, агааржуулалтыг өдөрт 2-3 удаа хийж, анги, танхимын дулааныг 18-20 хэмд тогтмол байлгах;

3.2. ТТӨ-ий шинж тэмдэгтэй болон өвчилсөн хүүхэд, багш ажилчдыг хичээл, сургуулиас эмчийн магадлагаагаар 7 хоног хүртэл чөлөөлж, гэрт нь тусгаарлах;

3.3. Ам, хамрын хөндийг байнга цэвэрлэн, хамраар зөв амьсгалах дасгал хийлгэж сургах;

3.4. Сургуулийн өдрийн цай, цэцэрлэгийн хоолны цэсийг амин дэмээр баялаг, илчлэг сайтай хоол хүнсээр бүрдүүлэх;

3.5. Цэцэрлэгийн хүүхдийн ор хоорондын зайг дор хаяж 1 метр байхаар төлөвлөж, зохицуулалт хийх;

3.6. Томуугийн дэгдэлтийн үед сургууль, цэцэрлэгт хүүхдийг олноор цуглуулан өдөрлөг, уулзалт, тэмцээн зохион байгуулахгүй байх;

3.7. Сургууль, цэцэрлэгийн хүүхдүүдэд ТТӨ-өөс урьдчилан сэргийлэх талаар сургалт сурталчилгаа хийх, халдвараас сэргийлэх энгийн арга (гарын ариун цэвэр сахих, амьсгалын замын халдвартай үед ханиаж, найтаахдаа ам, хамраа таглах гэх мэт)-ыг зааж сурган, хэвшүүлэх.

Эрүүл мэндийн сайдын 2014 оны
10 сарын 27 өдрийн 358 дугаар
тушаалын 4 дүгээр хавсралт

ТОМУУГИЙН ХАРУУЛДАН ТАНДАЛТЫН СОРЬЦ АВАХ, ХАДГАЛАХ, ТЭЭВЭРЛЭХ, ШИНЖЛЭХ ЖУРАМ

1. ТТӨ, АЗХХ, голомтолсон өвчлөлийн тохиолдлыг тодорхойлолтын дагуу оношлосон эмч, эмчилгээ эхлэхээс өмнө өвчний эхний 3 хоногт сорьц авна.

2. ТТӨ, АЗХХ, голомтолсон өвчлөлийн үед хамрын арчдас, хамрын угаадас, ийлдэс, тууралтат халдварын үед хоолойн арчдас, нас барсан тохиолдолд эд, эсийн сорьц авна.

3. Шинжлэгдэхүүн авах эмч, эрүүл мэндийн ажилтан хамгаалах хувцсыг бүрэн өмсөнө. Хэрэв өвчтний өгүүлэмж болон эмнэлзүйн шинж нь амьсгалын замын үүсгэгч тодорхойгүй, хүнд халдвар гэж сэжиглэхээр байвал HEPA шүүлтүүр бүхий зориулалтын амны хаалт зүүнэ.

3.1. Сорьц цуглуулахад дараахь зүйлийг бэлтгэнэ. Үүнд:
3.2. Халад
3.3. Маск
3.4. Бээлий
3.5. 7-8 см урт уян иштэй ариун бамбар
3.6. 2-4 мл вирүс зөөвөрлөх орчин бүхий бөглөөтэй хуруу шилнүүд
3.7. Хуруу шил тогтоогуур
3.8. Сорьц зөөвөрлөх зориулалтын сав
3.9. Сорьцыг дагалдах бичиг

4. Сорьц авахдаа дараах зааврыг баримтлана. Үүнд:

4.1. Хамрын арчдсыг авах: Өвчтөний нусыг нийлгэх буюу ариутгасан бамбараар хамрын хөндийг арчиж цэвэрлээд насанд хүрэгчдийг хэвтүүлж, хүүхдийг хүнд тэврүүлж суулгана. Зүүн гарын эрхий, долоовор хуруугаар өвчтөнийхээ хамрын үзүүрээс чимхэж, баруун гартаа ариун бамбар барьж болгоомжтой зөөлөн эргүүлэх хөдөлгөөнөөр хамрын дунд самалдаг хөндийн гүнд том хүнд 4-5 см, хүүхдэд 2-3 см оруулангаа бамбараа салст бүрхүүл рүү шахаж эргүүлэн арчдас авч, 2-3 мл буфержсэн ариун физиологийн уусмал буюу вирүс тээвэрлэх уусмалтай хуруу шилэнд хийнэ. Мөн энэ байдлаар хамрын нөгөө хөндийгөөс арчдас авч дээрх уусмалд хийнэ.

4.2. Хамрын угаадсыг авах: Өвчтөнийг дээрх байдлаар бэлтгэж, суулгаад хамрын хөндий тус бүрт зүүг уян гуурсаар орлуулсан тариураар 4-6 мл ариун физиологийн уусмал хийнгүүт буцаан соруулж ариун хуруу шилд хийнэ. Тариургүй үед дээрх уусмалыг хамарт дусаангуут өвчтөнийг бөхийлгөн

залгиулахгүйгээр ариун петрийн аяга юмуу юүлүүрээр дамжуулан хуруу шилэнд тосч авна.

4.3. Тууралтын шингэн авах: Цэврүүт тууралтын үед гарсан тууралтаас цэврүүний шингэнийг 1 мл-ийн хэмжээтэй тариураар соруулан авч тэжээлт орчин бүхий саванд хийнэ.

4.4. Тавны арчдас авах: Шархны тавны хэсгээс бамбараар арчдас авч, вирүс тээвэрлэх орчинтой хуруу шилэнд хийнэ.

4.5. Эд, эсийн сорьц авах: Уушгины эдийн гүнээс буюу гуурсан хоолойноос 0.5 см талтай шоо хэлбэртэй огтолж аваад ариун саванд хийж таглана.

4.6. Ийлдэс цуглуулах: Өвчтөний ийлдэст өвөрмөц эсрэг биеийн таньц тодорхойлох зорилгоор өвчтөнөөс 14-21 хоногийн зайтай хос ийлдсийг ердийн аргаар авна.

5. Сорьцыг хадгалах, зөөвөрлөхөд дараахь зааврыг баримтална.

5.1. Хамрын арчдас, хамрын угаадас, хоолойн арчдас, тууралтын шингэн, тавны арчдасыг нийслэлд 24 цагийн дотор мөсөн элемент бүхий саванд хийж, хөлдөөхгүйгээр тээвэрлэж, лабораторид хүргэнэ

5.2. Хөдөө орон нутагт өдөрт нь тээвэрлэх боломжгүй үед -70°С-д хадгалж, эсвэл мөсөн элементтэй саванд 48 цагийн хугацаанд хөлдөөхгүйгээр тээвэрлэж, лабораторид ирүүлнэ. Эд, эсийн сорьцийг хөлдөөхгүйгээр аль болох хурдан лабораторид хүргэнэ. Боломжгүй бол -70°С-д хадгалж, хөлдүүгөөр тээвэрлэнэ.

5.3. Ийлдсийг 7 хоногийн дотор лабораторид илгээх боломжтой бол хөлдөөлгүй сэрүүн нөхцөлд хадгалж, тээвэрлэнэ. Боломжгүй бол -20°С д хадгалж байгаад хөлдүүгээр тээвэрлэж лабораторид хүргэнэ.

5.4. Сорьц илгээсэн талаарх хэн, хэзээ, ямар тээврийн хэрэгслээр, ямар шинжлэгдэхүүнийг илгээж байгаа тухай бүрэн мэдээллийг харуулдан тандалтын нэгжийн ахлагч нар ХӨСҮТ-ийн Амьсгалын замын вирүс судлалын лабораторид 451183, 455847 дугаарын утсаар мэдэгдэнэ.

6. Сорьцыг хүргүүлэхэд дараах зааврыг баримтална.

6.1. Сорьцын дагалдах хуудсыг гаргацтай бөглөж, шинжлэгдэхүүний хамт лабораторид хүргүүлнэ.

6.2. Сорьцын дагалдах хуудас дараах загвартай байна.

Сорьц дагалдах хуудас №..../....

Эрүүл мэндийн байгууллагын нэр _____

Өвчтөний овог/нэр _____

Нас_____Хүйс: □ Эрэгтэй □ Эмэгтэй

Гэрийн хаяг _____

Эмнэлзүйн онош_____

Өвчин эхэлсэн: он/сар/өдөр: □□□□/□□/□□

Эмнэлэгт хэвтсэн: □□□□/□□/□□ он/сар/өдөр:

(АЗХХ-тай өвчтөн бол)
Сорьц авсан: он/сар/өдөр: □□□□/□□/□□

_____цаг _____ минут

Сорьц авах үеийн биеийн хэм:_____^{0}C

Томуугийн вакцин хийлгэсэн тухай: □Тийм □Үгүй □Мэдэхгүй\

Тийм бол хийлгэсэн: □□□□/□□/□□ он/сар/өдөр

Өвчтөн вирусын эсрэг эм хэрэглэсэн: □ Тийм □ Үгүй □ Мэдэхгүй Өвчтөн жирэмсэн эсэх: □ Тийм □ Үгүй □ Мэдэхгүй	Өвчтөн архаг хуучтай эсэх: □ Тийм □ Үгүй □ Мэдэхгүй Тийм бол тодруулна уу: □ Амьсгалын замын архаг өвчин □ Зүрхний өвчин □ Жин ихтэй (тарган) □ Даралт ихсэх □ Бөөрний өвчин □Чихрийн шижин □ Дархлал дутлын өвчнүүд □ Бусад _____

Цуглуулсан сорьцын төрөл: □Хамар залгиурын арчдас
□ Хоолойн арчдас
□ Хамрын угаадас
□ Уушгины аспират
□ Бусад _____

Сорьцыг тээвэрлэлтэнд өгсөн: он/сар/өдөр: □□□□/□□/□□

_____цаг ____ минут

Сорьц авсан эмч, сувилагчийн нэр: _____

7. Сорьцонд дараах шинжилгээг хийнэ. Үүнд:

7.1. Сорьц болгонд томуугийн вирус илрүүлэх шинжилгээг ердийн бүюу бодит хугацааны полимеразийн гинжин урвал (ПГУ);
7.2. Дээрх урвалаар эерэг гарсан сорьцыг эсийн өсгөвөр, тахианы үр хөврөлд халдааж томуугийн вирус ялгах шинжилгээ;
7.3. Вирусын өсгөврөөс цус наалдуулах, цус наалдуулахыг саатуулах урвалаар эсрэг төрөгчийн хэвшинжийг тодорхойлох;
7.4. ПГУ-аар вирусын дэд хэвшинж тодорхойлох;
7.5. Вирүсийн эмийн бодист тэсвэржилтийг ДЭМБ-ын зөвлөмж болгосон аргаар тодорхойлох;
7.6. Ийлдсэнд эсрэг биеийн таньц тодорхойлох шинжилгээг цус наалдахыг саатуулах, эсийн өсгөвөрт саармагжуулах аргаар тус тус хийнэ;
7.7. ПГУ-аар томуугийн вирус сөрөг гарсан сорьцны 15%-аас доошгүйд нь ТТӨ-ий бусад үүсгэгч илрүүлэх шинжилгээ хийнэ.

8. Шинжилгээний дүнг 7 хоног тутамд утсаар болон цахим хэлбэрээр эргэж мэдээлнэ.

9. Ялгасан вирусын төлөөлөл омгийг АНУ-ын Өвчний Хяналт, Сэргийлэлтийн Төв, Япон улсын Халдварт Өвчний Үндэсний Хүрээлэнгийн Томуугийн Лавлагаа төвд илгээнэ.

10. Томуугийн харуулдан тандалтын I зэрэглэлийн нэгжүүдийн эмч нар 7 хоногт 1-2 удаа ХӨСҮТ-ийн ТҮТ-ийн баталсан хуваарийн дагуу, II зэрэглэлийн цэгүүдийн эмч нар голомтолсон өвчлөл бүртгэгдсэн үед сорьц цуглуулж, дагалдах баримтын хамт "Шинжлэгдэхүүн авах, хадгалах, тээвэрлэх журам"-ын дагуу ХӨСҮТ-ийн Вирус судлалын лабораторид хүргэнэ.

11. Харуулдан тандалтын нэгжийн эмч нар ТТӨ-ий дархлал тогтцын шинжилгээнд зориулан зохих журмын дагуу цус авч ийлдсийг ялган ХӨСҮТ-ийн Вирус судлалын лабораторид ирүүлнэ.

12. Харуулдан тандалтын нэгжийн ахлагч нь тандалтын явцын байдлыг 14 хоног тутамд ТҮТ-д утас, цахим шуудан, факсаар мэдээлнэ.

Эрүүл мэндийн сайдын 2014 оны
10 сарын 17 өдрийн 388 дугаар
тушаалын 5 дугаар хавсралт

ТОМУУГИЙН ТАНДАЛТЫН ТОГТВОРТОЙ ХӨГЖЛИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ (2014-2018)

№	Үйл ажиллагаа	Санхүүжилт (сая төгрөгөөр)											
		12/13		13/14		14/15		15/16		16/17		17/18	
		ЗГ	АНУ/ бусад	ЗГ	Бусад	ЗГ	Бусад	ЗГ	Бусад	ЗГ	Бусад	ЗГ	Бусад
1. Томуугийн харуулдан тандалтын үйл ажиллагааг тогтворжуулан бэхжүүлэх													
1.1. Томуугийн эмнэлзүйн тандалтын үйл ажиллагааны тогтвортой байдлыг хангах													
1	Томуугийн эмнэлзүйн тандалтыг хэвийн, тогтмол явуулах, эмнэлгийн тусламж үйлчилгээний бэлэн байдлыг хангаж ажиллах.	6,850.0	0.0	6,850.0	0.0	7,500.0	0.0	8,000.0	0.0	8,500.0	0.0	9,000.0	0.0
2	Аймаг, дүүргийн ЭМГ, ЭМН-д томуугийн тандалт хариуцсан мэргэжилтнийг томилон, харуулдан тандалтын нэгжүүдийн хэвийн үйл ажиллагааг хангаж, удирдан чиглүүлж, хамтран ажиллах.	0.0	0.0	224.0	0.0	240.0	0.0	270.0	0.0	300.0	0.0	350.0	0.0

3	Тандалтын тогтолцоонд дэмжлэгт хяналт хийж, ажлын байранд сургалт зохион байгуулах.	12.0	28.0	40.0	0.0	45.0	0.0	50.0	0.0	55.0	0.0	60.0	0.0
4	Томуугийн харуулдан тандалтын нэгжүүдийн уулзалт, зөвлөлгөөнийг жил бүр зохион байгуулах.	0.0	70.0	70.0	0.0	80.0	0.0	90.0	0.0	100.0	0.0	110.0	0.0
5	Томуугийн тандалтанд хамрагдаж буй ӨЭМТ-үүдийн нэмэлт үйл ажиллагаанд зарцуулах төсвийг нэмэлтээр тусгах.	0.0	0.0	0.0	0.0	210.0	0.0	250.0	0.0	300.0	0.0	350.0	0.0
6	Томуугийн харуулдан тандалтын нэгжүүдийн үйл ажиллагааг үнэлэх үнэлгээний журмыг шатлал тус бүрээр боловсруулан шинэчлэх.	3.0	0.0	3.0	0.0	0.0	0.0	5.0	0.0	0.0	0.0	7.0	0.0

7	Томуугийн харуулдан тандалтын нэгжүүдийн үйл ажиллагааг улирал тутам үнэлэх.	1.5	0.0	1.5	0.0	2.0	0.0	2.0	0.0	3.0	0.0	3.0	0.0
1.2. Томуугийн лабораторийн тандалтын үйл ажиллагааг бэхжүүлж, шатчилан өргөжүүлэх													
8	Томуугийн лабораторийн сүлжээ, үйл ажиллагааг тогтмол, хэвийн байлгах.	190.0	12.0	190.0	0.0	210.0	0.0	230.0	0.0	250.0	0.0	280.0	0.0
9	Лабораториудын хэвийн үйл ажиллагаанд шаардлагатай урвалж оношлуур, бусад хэрэгсэлээр хангах, тоног төхөөрөмжийн засвар хийх нөхцлийг бүрдүүлэх.	160.0	90.0	200.0	50.0	200.0	80.0	200.0	110.0	240.0	100.0	280.0	100.0
10	Сорьц цуглуулах, хадгалах, тээвэрлэх үйл ажиллагааг хэвийн тогтмол явуулан, тээврийн байгууллагатай гэрээ хийн хамтран ажиллах.	9.0	10.0	25.0	5.0	30.0	4.0	33.0	3.0	37.0	3.0	40.0	3.0
11	Салбар лабораторийн үйл ажиллагааг тогтмол, хэвийн байлгах.	18.0	46.0	51.0	10.0	60.0	10.0	65.0	10.0	70.0	10.0	80.0	10.0
12	Сорьц авах, шинжилгээ хийх аргачлал, интернэтэд сорьцийн мэдээлэл оруулах талаарх сургалт хийх.	10.0	10.0	10.0	10.0	12.0	10.0	14.0	10.0	17.0	10.0	20.0	0.0

13	Гадаад, дотоодын чанарын хяналтыг тогтмолжуулах.	0.0	2.0	2.0	0.0	2.0	0.0	3.0	0.0	3.0	0.0	3.0	0.0
1.3. Томуугийн мэдээллийн тогтолцооны тогвортой байдлыг ханган бэхжүүлэх													
14	Томууҗийн мэдээллийн тогтолцоог тогтмол, хэвийн явуулах нөхцлийг бүрдүүлэх.	548.0	0.0	548.0	0.0	600.0	0.0	650.0	0.0	700.0	0.0	750.0	0.0
15	Томуугийн мэдээллийн системийн хэвийн үйл ажиллагааг хангах (утас, интернет гэх мэт).	30.0	20.0	57.0	0.0	65.0	0.0	70.0	0.0	75.0	0.0	80.0	0.0
16	ТҮТ-ийн вэб сайтыг хэвийн тогтмол ажиллуулах.	0.0	15.0	15.0	0.0	17.0	0.0	19.0	0.0	21.0	0.0	23.0	0.0
17	Тандалтын нэгжүүдтэй сар бүр аудио хурал хийх.	2.4	0.2	2.4	0.0	3.0	0.0	3.0	0.0	4.0	0.0	4.0	0.0
1.4. Мал, амьтны томуугийн тандалтын үйл ажиллагааг бэхжүүлж, шатчилан өргөжүүлэх													
18	Мал эмнэлгийн ариун цэврийн төв лаборатори, ЗӨСҮТ зэрэг мал амьтны өвчин судалдаг байгууллагуудтай хамтран ажиллах, мэдээлэл солилцох	2.0	0.0	2.0	0.0	2.5	0.0	3.0	0.0	3.5	0.0	4.0	0.0
19	Томуугийн харуулдан тандалтын нэгжүүдийн харъяанд харъяалагдах мал аж ахуй эрхлэгчдийн судалгааг жил бүр шинэчлэх.	10.0	0.0	10.0	0.0	11.0	0.0	12.0	0.0	13.0	0.0	14.0	0.0

20	Салбар хоорондын уулзалт, зөвлөлгөөн зохион байгуулах.	0.0	10.0	11.0	9.0	12.0	8.0	13.0	7.0	14.0	6.0	15.0	5.0
21	Уулзалт, ярилцлагаас гарсан шийдвэр дээр үндэслэн бүсчилсэн сургалт, ярилцлага зохион байгуулах.	0.0	6.0	7.0	6.0	8.0	6.0	9.0	6.0	10.0	6.0	11.0	6.0
1.5. Томуугийн тандалтын эрүүл мэндийн үйлчилгээний шатлал, салбар хоорондын болон олон улсын хамтын ажиллагааг бэхжүүлэн өргөжүүлэх													
22	ДЭМБ-ын Томуугийн Лавлагаа Төвүүдтэй хамтран ажиллах.	10.0	0.0	10.0	0.0	12.0	0.0	14.0	0.0	16.0	0.0	18.0	0.0
23	FluNet зэрэг олон улсын томуугийн сүлжээнд томуугийн тандалтын мэдээ, мэдээллийг тогтмол хүргүүлэх.	1.0	0.0	1.0	0.0	1.1	0.0	1.3	0.0	1.5	0.0	2.0	0.0
24	Боловсон хүчний мэдлэг мэргэжлийг дээшлүүлэх, туршлага солилцох зорилгоор гадаадын сургалт, семинар, томуугийн үндэсний төвүүдийн бүсийн зөвлөлгөөнд оролцох.	15.0	15.0	15.0	15.0	20.0	20.0	25.0	25.0	30.0	30.0	35.0	35.0
25	Гадаад хяналтыг явуулах.	0.0	5.0	0.0	5.0	0.0	6.0	0.0	7.0	0.0	8.0	0.0	10.0

2. Томуугийн дэгдэлтийн эсрэг хариу арга хэмжээний тогтолцоог бэхжүүлэн сайжруулах													
2.1. Эмнэлгийн яаралтай тусламж үзүүлэх нөхцлийг ханган ажиллах, чадварыг нэмэгдүүлэх													
26	Амьсгалын замын хүнд халдвартай, амьсгалын дуталтай өвчтөнүүдэд эмнэлгийн яаралтай тусламж үзүүлэхэд шаардлагатай орчин үеийн багаж тоног төхөөрөмжийг нэмэгдүүлэх.	0.0	0.0	0.0	0.0	500.0	500.0	100.0	100.0	50.0	50.0	50.0	50.0
27	Дэгдэлтийн үеийн эмнэлзүйн менежментийн гарын авлага, заавар журам, удирдамжийг шинэчлэн боловсруулж, тараах.	10.0	0.0	10.0	0.0	10.0	0.0	15.0	0.0	15.0	0.0	15.0	0.0
28	Шатлал бүрээс эмнэлзүйн эмч нарыг гадаад, дотоодын сургалт, туршлага солилцох, мэргэжил дээшлүүлэх сургалтанд оролцуулах.	15.0	15.0	30.0	5.0	40.0	3.0	45.0	3.0	50.0	3.0	55.0	2.0
2.2. Дэгдэлтийн үед ажиллах мэргэжлийн багийн бэлэн байдлыг хангах, чадавхжуулах													
29	Мэргэжлийн багийн (ХХХ, багаж тоног төхөөрөмж, хүний нөөц, халдваргүйтгэлийн бодис гэх мэт) бэлэн байдлыг хангах.	50.0	0.0	50.0	0.0	55.0	0.0	60.0	0.0	65.0	0.0	70.0	0.0

30	Томуугийн дэгдэлтийн үед мэргэжлийн багийг аймаг, орон нутагт ажиллуулах.	40.0	0.0	40.0	0.0	45.0	0.0	50.0	0.0	55.0	0.0	60.0	0.0
31	Салбар дундын төлөөллийг оролцуулж үзүүлэх сургууль, ширээний дасгалыг бүсчилж зохион байгуулах.	0.0	0.0	50.0	0.0	60.0	0.0	65.0	0.0	70.0	0.0	75.0	0.0
2.3. Томуугийн цартахлын болон томуугийн шинэ вирусийн халдварын үеийн бэлэн байдлыг хангах													
32	Вирусийн эсрэг эм бэлдмэлийн нөөцийн бэлэн байдлыг хангах.	1,500.0	0.0	1,500.0	200.0	2,00.0	300.0	2,500.0	400.0	3,000.0	500.0	3,500.0	500.0
33	Томуугийн цартахлын болон томуугийн шинэ вирусийн халдварын үеийн бэлэн байдлыг хангаж ажиллах болон хүний нөөцийн дайчилгааны төлөвлөгөөг боловсруулах, шинэчлэлт тогтмол хийх.	5.0	5.0	10.0	0.0	15.0	0.0	20.0	0.0	22.0	0.0	25.0	0.0
34	Томуугийн цартахлын бэлэн байдлын үндсэн чадавхийг эрүүл мэндийн байгууллагуудад 2 жил тутамд үнэлэх.	0.0	0.0	30.0	20.0	0.0	0.0	40.0	10.0	0.0	0.0	0.0	0.0

35	Сургалт, сурталчилгааны материал, гарын авлага, сэрэмжлүүлэг, брошюр боловсруулах, хэвлүүлж, тарааж сургалт, сурталчилгааг олон нийтийн хэрэгслээр явуулах.	60.0	20.0	60.0	5.0	75.0	4.0	85.0	3.0	95.0	2.0	105.0	2.0
36	Томуугийн дэгдэлт, цартахлын үед шарилыг байршуулах байрыг нэмэгдүүлж, нөхцлийг сайжруулах төлөвлөгөө боловсруулан хэрэгжүүлж эхлэх.	10.0	0.0	10.0	0.0	60.0	0.0	100.0	0.0	200.0	0.0	300.0	0.0
2.4. Томуугийн дархлаажуулалтыг нэмэгдүүлэх													
37	Томуугийн дархлаажуулалтыг нэмэгдүүлэх (тархвар судлалын заалтаар болон сайн дурын дархлаажуулалт).	200.0	0.0	200.0	0.0	250.0	0.0	450.0	50.0	500.0	0.0	600.0	0.0

Эрүүл мэндийн сайдын 2014 оны
10 сарын 27 өдрийн 358 дугаар
тушаалын 6 дугаар хавсралт

ТОМУУГИЙН ХАРУУЛДАН ТАНДАЛТЫН I, II
ЗЭРЭГЛЭЛИЙН НЭГЖИЙН ЖАГСААЛТ

Нэг. Томуугийн харуулдан тандалтын I зэрэглэлийн нэгж

1.1 Улаанбаатар хот дахь амбулаторид суурилсан томуугийн харуулдан тандалтын I зэрэглэлийн нэгжүүд –Өрхийн эрүүл мэндийн төвүүд

Дүүргийн нэр	Өрхийн эрүүл мэндийн төвийн нэр
Баянзүрх	1. "Амгалан итгэхүй 2. "Эрүүл өрх", 3. "Насан урт"
Хан-Уул	4. "Энх титэм", 5. "Манал үйлс", 6. "Амин тус"
Сүхбаатар	7. "Санколл", 8. "Энх сүндэр", 9. "Үйлс нэгтэн"
Сонгинохайрхан	10. "Буянт манал", 11. "Энх-Элбэрэл", 12. "Өнө-ачит"
Баянгол	13. "Итгэл угтах", 14. "Гурван санчир", 15. "Шар дэгд"
Чингэлтэй	16. "Тэгш мэнд", 17. "Шижид дүг", 18. "Тэгш–Өлзий"
Багануур	19. "Энэрэлт–Өлзий" 20. "Биваангирд", 21. "Энх Өрх", 22. "Ач Элбэрэл"
Налайх	23. "Амь-Эрдэнэ"

1.2 Хөдөө орон нутаг дахь амбулаторт суурилсан томуугийн харуулдан тандалтын I зэрэглэлийн нэгжүүд –Өрхийн эрүүл мэндийн төв

Аймгийн нэр	Өрхийн эрүүл мэндийн төвийн
Дорноговь	1. "Агатова" 2. "Гоёомэнд", 3. "Мишээлт мана", 4. "Төмөр зам",

Дорнод	5. “Асралт үйлс”,
	6. “Мянган жаргалан”,
	7. “Ягаан цээнэ”
Өвөрхангай	8. “Наран дөш”,
	9. “Түшиг дөлгөөн”,
	10. “Уян сэтгэл”,
	11. “Энхийн хүрд”
Сэлэнгэ	12. “Зөвлөх”,
	13. “Номтхан”,
	14. “Хадан хүй”,
	15. “Эмнэх”
Ховд	16. “Баатархайрхан”,
	17. “Бугат”,
	18. “Буянт”,
	19. “Жаргалант”,
	20. “Рашаант”
Орхон	21. “Үйлсбадрах”,
	22. “Ачлалт нар”,
	23. “Анхны оч”,
	24. “Итгэлийн эрэл”,
	25. “Нийцэл”,
	26. “Мөнхийн гэгээ”,
	27. “Мөнхсүндрэл”,
	28. “Мэндбулаг”,
	29. “Учралтбаяр”,
	30. “Гэрэлт мандах”,
	31. “Энхжинмандирваа”,
	32. “Элбэрэлт Үйлс”
Дархан-Уул	33. “Гос хот”,
	34. “Энэрэлт наран”,
	35. “Гэрэлтэй”,
	36. “Аминхолбоо”,
	37. “Түвшинхолбоо”
Дорноговь Замын-Үүд	38. “Орхой наран”

1.3 Улаанбаатар хот дахь эмнэлэгт суурилсан томуугийн харуулдан тандалтын I зэрэглэлийн нэгжүүд – Тусгай мэргэжлийн төв, Дүүргийн нэгдсэн эмнэлгүүд

1. Баянзүрх дүүргийн Нэгдсэн эмнэлэг
2. Хан-Уул дүүргийн Нэгдсэн эмнэлэг
3. Сүхбаатар дүүргийн Нэгдсэн эмнэлэг
4. Сонгинохайрхан дүүргийн Нэгдсэн эмнэлэг
5. Баянгол дүүргийн Нэгдсэн эмнэлэг
6. Чингэлтэй дүүргийн Нэгдсэн эмнэлэг
7. Багануур дүүргийн Нэгдсэн эмнэлэг
8. Эх хүүхдийн эрүүл мэндийн үндэсний төв
9. Халдварт өвчин судлалын үндэсний төв

1.4 Хөдөө орон нутаг дахь эмнэлэгт суурилсан томуугийн харуулдан тандалтын I зэрэглэлийн нэгжүүд – БОЭТ, Аймгийн нэгдсэн эмнэлэг, Сумын нэгдсэн эмнэлэг

1. Дорноговь аймгийн Нэгдсэн эмнэлэг
2. Дорнод аймаг дахь БОЭТ
3. Өвөрхангай аймаг дахь БОЭТ
4. Сэлэнгэ аймгийн Нэгдсэн эмнэлэг
5. Ховд аймаг дахь БОЭТ
6. Орхон аймаг дахь БОЭТ
7. Дархан-Уул аймгийн Нэгдсэн эмнэлэг
8. Дорноговь аймгийн Замын-Үүд сумын Нэгдсэн эмнэлэг

Хоёр. Томуугийн харуулдан тандалтын II зэрэглэлийн нэгжүүд

2.1 Улаанбаатар хот дахь харуулдан тандалтын II зэрэглэлийн нэгжүүд

1. Улсын Клиникийн 1-р эмнэлэг
2. Шастины нэрэмжит нэгдсэн 3-р эмнэлэг
3. Хавдар судлалын үндэсний төв

2.2 Хөдөө орон нутаг дахь амбулаторид суурилсан томуугийн харуулдан тандалтын II зэрэглэлийн нэгжүүд

Аймгийн нэр	Өрхийн эрүүл мэндийн төвүүд
Архангай	1. "Ар энхжин", 2. "Ар мөнгөн чагнуур", 3. "Ар мөнхжин", 4. "Ар рашаант", 5. "Ар манал"
Баян-өлгий	6. "Шипагер" 7. "Жансая" 8. "Рауан" 9. "Мейрим"
Баянхонгор	10. "ЭБСУ" 11. "Наран мандмал" 12. "Супрессор", 13. "Оточ мандал"
Булган	14. "Энхбүрд" 15. "Оточ номгон" 16. "Эмийн цэцэглэн", 17. "Цоожид"
Говь-Алтай	18. "Жаргалан алтай", 19. "Марал алтай", 20. "Энх алтай"
Говьсүмбэр	21. "Энх тус дэм"
Завхан	22. "Биндэргарав", 23. "Дөрвөн оноо", 24. "Наран мөнхийн алба", 25. "Надсэлмамба"

Дундговь	26. “Суварга эрдэнэ”
	27. “Боржигон мандал”
	28. “Өлзийт мандал”
Өвөрхангай,Хархорин сум	29. “Энэрэлт-Хархорин”
Өмнөговь	30. “Шинэ билэг”
	31. “Энхийн хүслэн”,
	32. “Өнө Орших”
Төв	33. “Баруун зуун мод”,
	34. “Биндэръяа зуун мод”,
Сэлэнгэ, Мандал	35. “Баян”,
	36. “Бату”,
	37. “Ачит баг”
Сэлэнгэ, Алтанбулаг	38. Сумын эрүүл мэндийн төв
Сүхбаатар	39. “Энэрэл”,
	40. “Энхжин”,
	41. “Тэмүүлэн”
	42. “Элбэг-өгөөж”,
Увс	43. “Дунцагаан”,
	44. “Мөнхбишрэлт”,
	45. “Батүржихүй”
Хэнтий	46. “Ач манал”,
	47. “Хэрлэн дом”,
	48. “Оюуны шим”
Хөвсгөл	49. “Эрчим”,
	50. “Дэлгэр мөрөн”,
	51. “Буян”,
	52. “Энэрэл”,
	53. “Тулга”,
	54. “Далай-Элбэрэл”

2.3 Хөдөө орон нутагт дахь эмнэлэгт суурилсан томуугийн харуулдан тандалтын II зэрэглэлийн нэгжүүд

1. Архангай аймгийн Нэгдсэн эмнэлэг
2. Баян-өлгий аймгийн Нэгдсэн эмнэлэг
3. Баянхонгор аймгийн Нэгдсэн эмнэлэг
4. Булган аймгийн Нэгдсэн эмнэлэг
5. Говь-Алтай аймгийн Нэгдсэн эмнэлэг
6. Говьсүмбэр аймгийн Нэгдсэн эмнэлэг
7. Завхан аймгийн Нэгдсэн эмнэлэг
8. Дундговь аймгийн Нэгдсэн эмнэлэг
9. Өвөрхангай, Хархорин сумын Нэгдсэн эмнэлэг
10. Өмнөговь аймгийн Нэгдсэн эмнэлэг
11. Төв аймгийн Нэгдсэн эмнэлэг
12. Сэлэнгэ, Мандал сумын нэгдсэн эмнэлэг
13. Сэлэнгэ, Алтанбулаг сумын нэгдсэн эмнэлэг
14. Сүхбаатар аймгийн Нэгдсэн эмнэлэг
15. Увс аймгийн Нэгдсэн эмнэлэг
16. Хэнтий аймгийн Нэгдсэн эмнэлэг
17. Хөвсгөл аймгийн Нэгдсэн эмнэлэг